



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сант сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/128-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2022 он</p>	<p>Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас:70363040; Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Батмөнх Утас:70363036; Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Т.Болор</p> <p>Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс баланс аудит” ХХК Утас: 77270808; Цахим хаяг: nitsbalance@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

<u>1. Аудитын санал дүгнэлт</u>	3
<u>2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл</u>	4-10
<u>3. Аудитын тайлан</u>	11
<u>3.1 Ерөнхий зүйл</u>	11
<u>3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт</u>	11
<u>3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал</u>	12
<u>3.4 Материаллаг байдал</u>	13
<u>3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга</u>	13
<u>3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв</u>	14
<u>3.6.1 Төсвийн төлөвлөлт</u>	14
<u>3.6.2 Төсвийн гүйцэтгэл</u>	14
<u>3.6.3 Нэмэлт төсөв</u>	15
<u>3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг</u>	15
<u>3.8 Аудитын гол асуудал</u>	15
<u>3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</u>	15
<u>3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт</u>	15-16
<u>3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд</u>	16
<u>3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</u>	16
<u>3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал</u>	16
<u>4. Аудитын илрүүлэлт</u>	17
4.1 Залруулсан алдаа.....	17
4.2	
<u>5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл</u>	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан



САНТ СУМЫН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Л.ХҮРЭЛМАА ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II бэг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА-2022/128-НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сант сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Сант сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөө дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	34,240,753.28	31,081,943.80
33	АВЛАГА	31,778.78	0.00
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	31,778.78	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	34,208,974.50	31,081,943.80
351	Түүхий эд материал	562,700.00	0.00
3511	Тусгай зориулалттай материал	562,700.00	0.00
354	Хангамжийн материал	33,646,274.50	31,081,943.80
3541	Бичиг хэргийн материал	167,000.00	0.00
3542	Аж ахуйн материал	20,827,493.00	0.00
3545	Барилгын засварын материал	4,794,960.00	0.00
3546	Хүнсний материал	2,010,271.50	1,946,600.80
3547	Бусад хангамжийн материал	5,846,550.00	29,135,343.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	311,693,768.35	298,887,626.35
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	311,693,768.35	298,887,626.35
392	Биет хөрөнгө	295,908,834.99	283,352,692.95
39201	Барилга, байгууламж, орон сууц	286,738,600.00	286,738,600.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-23,982,039.60	-35,973,059.40
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	39,318,325.00	44,963,515.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-22,920,410.26	-26,769,197.38
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,179,050.00	17,179,050.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,524,690.03	-9,391,015.11
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,000,000.00	10,754,800.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,750,000.12	-5,000,000.16
39217	Ном	850,000.00	850,000.00
393	Биет бус хөрөнгө	15,784,933.36	15,534,933.40
39301	Програм хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-166,666.64	-416,666.60
39303	Бусад биет бус хөрөнгө	14,701,600.00	14,701,600.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	345,934,521.63	329,969,570.15
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	345,934,521.63	329,969,570.15
51	Засгийн газрын хувь оролцоо	345,934,521.63	329,969,570.15
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	145,152,995.00	145,152,995.00
51101	Өмч: - төрийн	145,152,995.00	145,152,995.00
512	Хуримтлагдсан үр дүн	186,935,875.04	170,970,923.56
5121	Өмнөх үеийн үр дүн	186,935,875.04	186,935,875.04
5122	Тайлант үеийн үр дүн		-15,964,951.48
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	13,845,651.59	13,845,651.59
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	345,934,521.63	329,969,570.15

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	317,338,855.26	295,035,446.19
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,188,065.00	465,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	55,440.00	73,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	55,440.00	73,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	55,440.00	73,600.00
122	Тусламжийн орлого	20,132,625.00	391,500.00
122001	Хандив тусламж /дотоод/	20,132,625.00	391,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	297,150,790.26	294,570,346.19
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	287,817,190.26	294,368,346.19
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	20,155,690.26	20,533,146.19
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	267,661,500.00	273,835,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	202,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	202,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	9,333,600.00	0.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	9,333,600.00	0.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	288,982,215.31	311,000,397.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	288,982,215.31	311,000,397.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	264,948,843.01	288,656,249.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	187,291,413.47	203,652,739.64
210101	Үндсэн цалин	143,146,608.46	155,064,379.25
210102	Нэмэгдэл	29,509,577.31	32,287,060.39
210104	Урамшуулал	14,635,227.70	16,301,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,879,523.45	26,592,335.53
210201	Тэтгэврийн даатгал	15,932,513.15	18,560,533.18
210202	Тэтгэмжийн даатгал	1,930,086.72	2,063,807.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,500,389.29	1,627,780.02
210204	Ажилгүйдлийн даатгал	729,358.66	393,240.99
210205	Эрүүл мэндийн даатгал	3,787,175.63	3,946,974.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,584,439.46	20,010,146.19
210301	Гэрэл, цахилгаан	2,859,960.40	3,082,924.89
210302	Түлш, халаалт	14,448,379.06	16,671,121.30
210303	Цэвэр, бохир ус	276,100.00	256,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,971,838.00	3,369,285.00
210401	Бичиг хэрэг	213,100.00	666,700.00
210402	Тээвэр, шатахуун	350,098.00	295,520.00

Сэлэнгэ аймгийн Сант сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	69,300.00	437,700.00
210404	Ном, хэвлэл	62,300.00	30,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	831,540.00	1,742,365.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	445,500.00	197,000.00
2105	Нормативт зардал	10,534,092.50	6,763,250.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	54,600.00	60,000.00
210502	Хоол, хүнс	9,908,992.50	5,944,750.70
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	570,500.00	758,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,380,040.00	6,454,860.00
210604	Урсгал засвар	2,380,040.00	6,454,860.00
2107	Томилолт, зочны зардал	87,400.00	98,000.00
210702	Дотоод албан томилолт	87,400.00	98,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	653,200.00	1,016,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	329,200.00	368,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,566,896.13	20,698,932.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	692,100.00	22,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,365,102.00	1,469,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,509,694.13	19,206,132.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,033,372.30	22,344,148.61
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,033,372.30	22,344,148.61
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,033,372.30	22,344,148.61
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	28,356,639.95	-15,964,951.48
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	28,356,639.95	-15,964,951.48

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	145,152,995.00	13,845,651.59	186,935,875.04	345,934,521.63
2	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	145,152,995.00	13,845,651.59	186,935,875.04	345,934,521.63

3	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	145,152,995.00	13,845,651.59	186,935,875.04	345,934,521.63
5	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
6	Тайлант үеийн үр дүн			-15,964,951.48	-15,964,951.48
7	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	145,152,995.00	13,845,651.59	170,970,923.56	329,969,570.15

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	297,150,790.26	294,570,346.19
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	297,150,790.26	294,570,346.19
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	287,817,190.26	294,368,346.19
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	20,155,690.26	20,533,146.19
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	267,661,500.00	273,835,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	202,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	202,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	9,333,600.00	0.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	9,333,600.00	0.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	282,377,990.26	288,170,356.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	282,377,990.26	288,170,356.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	258,344,617.96	265,826,207.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	188,211,215.21	203,652,739.64
210101	Үндсэн цалин	135,975,639.20	155,064,379.25
210102	Нэмэгдэл	37,600,348.31	32,287,060.39
210104	Урамшуулал	14,635,227.70	16,301,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,822,400.49	26,560,556.75
210201	Тэтгэврийн даатгал	16,356,952.27	18,528,754.40
210202	Тэтгэмжийн даатгал	1,930,086.72	2,063,807.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,521,017.71	1,627,780.02
210204	Ажилгүйдлийн даатгал	338,730.20	393,240.99
210205	Эрүүл мэндийн даатгал	3,675,613.59	3,946,974.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,359,730.26	20,010,146.19
210301	Гэрэл, цахилгаан	4,635,251.20	3,082,924.89
210302	Түлш, халаалт	14,448,379.06	16,671,121.30
210303	Цэвэр, бохир ус	276,100.00	256,100.00

Сэлэнгэ аймгийн Сант сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	3,110,400.00	2,859,185.00
210401	Бичиг хэрэг	85,600.00	545,900.00
210402	Тээвэр, шатахуун	333,000.00	295,585.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	69,300.00	437,700.00
210404	Ном, хэвлэл	62,300.00	30,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,460,000.00	877,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,100,200.00	672,600.00
2105	Нормативт зардал	13,414,772.00	6,533,080.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	54,600.00	60,000.00
210502	Хоол, хүнс	8,785,772.00	5,849,080.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,574,400.00	624,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,467,700.00	3,489,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	260,000.00	
210604	Урсгал засвар	7,207,700.00	3,489,400.00
2107	Томилолт, зочны зардал	87,400.00	98,000.00
210702	Дотоод албан томилолт	87,400.00	98,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	653,200.00	1,016,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	329,200.00	368,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,217,800.00	1,606,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	715,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,502,800.00	1,606,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,033,372.30	22,344,148.61
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,033,372.30	22,344,148.61
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,033,372.30	22,344,148.61
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	14,772,800.00	6,399,990.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,439,200.00	6,399,990.00
22	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах	5,439,200.00	6,399,990.00
	Дотоод эх үүсвэрээр	5,439,200.00	6,399,990.00
222001	Тоног төхөөрөмж		6,399,990.00
223001	Бусад хөрөнгө	5,439,200.00	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-5,439,200.00	-6,399,990.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	9,333,600.00	0.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Сэлэнгэ аймгийн Сант сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	299,074,100.00	272,024,197.58	27,049,902.42	90.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	299,074,100.00	265,624,207.58	33,449,892.42	88.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	299,074,100.00	265,624,207.58	33,449,892.42	88.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	214,243,700.00	203,652,739.64	10,590,960.36	95.0
210101	Үндсэн цалин	166,373,600.00	155,064,379.25	11,309,220.75	93.2
210102	Нэмэгдэл	31,568,800.00	32,287,060.39	-718,260.39	102.2
210104	Урамшуулал	16,301,300.00	16,301,300.00	0.00	100
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,005,100.00	26,560,556.75	1,444,543.25	94.8
210201	Тэтгэврийн даатгал	19,395,400.00	18,528,754.40	866,645.60	95.5
210202	Тэтгэмжийн даатгал	2,152,400.00	2,063,807.22	88,592.78	95.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,721,900.00	1,627,780.02	94,119.98	94.5
210204	Ажилгүйдлийн даатгал	430,500.00	393,240.99	37,259.01	91.3
210205	Эрүүл мэндийн даатгал	4,304,900.00	3,946,974.12	357,925.88	91.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,715,900.00	20,010,146.19	4,705,753.81	80.9
210301	Гэрэл, цахилгаан	6,650,900.00	3,082,924.89	3,567,975.11	46.3
210302	Түлш, халаалт	17,788,900.00	16,671,121.30	1,117,778.70	93.7
210303	Цэвэр, бохир ус	276,100.00	256,100.00	20,000.00	92.7
2104	Хангамж, бараа материалын зардал	2,665,900.00	2,657,185.00	8,715.00	99.6
210401	Бичиг хэрэг	545,900.00	545,900.00	0.00	100
210402	Тээвэр, шатахуун	264,600.00	295,585.00	-30,985.00	111.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	437,700.00	437,700.00	0.00	100
210404	Ном, хэвлэл	69,700.00	30,000.00	39,700.00	43.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	675,400.00	675,400.00	0.00	100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	672,600.00	672,600.00	0.00	100
2105	Нормативт зардал	16,509,000.00	6,533,080.00	9,975,920.00	39.5
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	61,100.00	60,000.00	1,100.00	98.2
210502	Хоол, хүнс	15,804,500.00	5,849,080.00	9,955,420.00	37.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	643,400.00	624,000.00	19,400.00	96.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,889,400.00	3,489,400.00	6,400,000.00	35.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,400,000.00	0.00	6,400,000.00	
210604	Урсгал засвар	3,489,400.00	3,489,400.00	0.00	100
2107	Томилолт, зочны зардал	98,000.00	98,000.00	0.00	100
210702	Дотоод албан томилолт	98,000.00	98,000.00	0.00	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,340,700.00	1,016,700.00	324,000.00	75.8

Сэлэнгэ аймгийн Сант сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	368,700.00	368,700.00	0.00	100
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	972,000.00	648,000.00	324,000.00	66.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,606,400.00	1,606,400.00	0.00	100
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,606,400.00	1,606,400.00	0.00	100
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	6,399,990.00	-6,399,990.00	
	Дотоод эх үүсвэрээр	0.00	6,399,990.00	-6,399,990.00	
222001	Тоног төхөөрөмж	0.00	6,399,990.00	-6,399,990.00	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	299,074,100.00	272,024,197.58	27,049,902.42	90.9
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	299,074,100.00	272,024,197.58	27,049,902.42	90.9
131001	Улсын төсвөөс санхүүжих	25,238,900.00	20,533,146.19	4,705,753.81	81.3
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	273,835,200.00	251,491,051.39	22,344,148.61	91.8
1	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100
2	Төсвийн байгууллага	1	1	0.00	100
3	АЖИЛЛАГСДЫН ТОО	20.5	20.5	0.00	100
4	Удирдах ажилтан	1	1	0.00	100
5	Гүйцэтгэх ажилтан	11.5	11.5	0.00	100
6	Үйлчлэх ажилтан	8	8	0.00	100
7	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	119	119	0.00	100

2.5 Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	202,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	202,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	202,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	202,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	202,000.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	202,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	202,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	202,000.00
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сант сумын 1 дүгээр цэцэрлэгийн /цаашид Сант сумын 1 дүгээр цэцэрлэг гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн төлөвлөлт болон тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу аудитыг “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК-ийн аудитор Н.Батбаяр хариуцаж хэрэгжүүлэв. Аудитын анхан шатны чанарын хяналтыг “Эн Ай Ти Эс баланс Аудит ХХК-ийн менежер И.Туяа, захирал Ш.Ичинхорлоо, дараагийн шатны чанарын хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар гүйцэтгэв.

Сант сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Эн Ай Ти Эс Баланс Аудит ХХК-д хянуулахаар 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сант сумын 1 дүгээр цэцэрлэг үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад бүх талуудтай хамтран ажиллая” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгын хүрээнд үйл ажиллагааны дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Хүүхэд бүрийг тэгш хамруулан сургах, боломж нөхцөлийг бүрдүүлэх;
- Гэнэтийн болон байгалийн хүчин зүйлийн үед хичээл, сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангаж цахим болон даалгаврын сан бүрдүүлэн ажиллах;
- Багш, удирдах ажилтан бүр сургалтын арга хэлбэрийг оновчтой сонгон, заах арга зүйгээ хөгжүүлж хамтран ажиллах;

- “Сургалтын байгууллага-тоног төхөөрөмж” арга хэмжээний хүрээнд цэцэрлэг бүрийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлэн, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх;
- Судалгаа арга зүйн байгууллагатай хамтран ажиллаж, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгахад дэмжлэг үзүүлэн сургалт үйл ажиллагааны чанарыг сайжруулж ажиллах;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- ЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор баталсан “Ковид 19” цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай”;
- ЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 267 дугаар тушаалаар баталсан “Цахилгаан, дулааны уурын хангамж, хэрэглээг зохицуулах тухай”.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сант сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр

дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 311,000.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 6,220.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4,976.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сант сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4.6 хувь буюу 15,965.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Ажиллагсадтай холбогдсон авлага	31.8	-	(31.8)
Бараа материал	34,208.9	31,081.9	(3,127.0)
Үндсэн хөрөнгө	311,693.8	298,887.6	(12,806.2)
Нийт хөрөнгө	345,934.5	329,969.5	(15,965.0)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	345,934.5	329,969.5	(15,965.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	345,934.5	329,969.5	(15,965.0)

Бараа материалын дансны үлдэгдэл 31,081.9 мянган төгрөг болж өмнөх оноос 3,127.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 12,611.0 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авсан, ДЗОУБ-аас 391.5 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авч, 16,129.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 376,437.6 мянган төгрөг болж, 6,400.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр тоног төхөөрөмж худалдан авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 329,969.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 15,965.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үр дүнгээс шалтгаалсан байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 295,035.4 мянган төгрөг болж өмнөх оноос 22,303.5 мянган төгрөгөөр буурсан нь хандив тусламжийн орлого буурснаас шалтгаалсан байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт зардал 311,000.4 мянган төгрөг болж өмнөх оноос 22,017.8 мянган төгрөгөөр буюу 7.6 хувиар өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 499,693.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 200,565.4 мянган төгрөгөөр бууруулж 299,074.1 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 2 зориулалт, арга хэмжээний санхүүжилтэд **299,074.1** мянган төгрөг баталснаас 273,835.2 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих, 25,238.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тус тус төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 273,835.2 мянган төгрөг төгрөг, орон нутгийн төсвөөс 20,533.1 мянган төгрөгийн, нийт 294,368.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлэн, урсгал үйл ажиллагааны зардалд 272,024.2 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 22,344.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **272,024.2** мянган төгрөг буюу 90.9 хувьтай байгаа нь цалин, НДШ-ийн зардал 12,035.4 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 4,705.8 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 8.7 мянган төгрөгөөр, нормативт зардал 9,975.9 мянган төгрөгөөр, багаж техник хэрэгслийн зардал 6,400.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 324.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн БСГ-аас хог хаягдал зайлуулах, ариутгалын зардалд 202.0 мянган төгрөг олгосныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

1. БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай” тушаалын нэгдүгээр хавсралт “*Коронавируст халдварын үед цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам*”-ын дагуу сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 131 мэдээллийг хугацаанд нь, 18 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Сант сумын 1 дүгээр цэцэрлэгийн тайлант оны үйл ажиллагаанд 299,074.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 272,024.2 мянган төгрөгийг зарцуулж, батлагдсан төсөвт зардлыг 9.1 хувиар хэмнэсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....*батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 245.3 мянган төгрөгийн төлбөрийн акт, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой 1 зөвлөмж өгснөөс төлбөрийн актыг барагдуулж, зөвлөмжийг биелүүлээгүй байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	245.3	1	245.3	-	-	100.0
Зөвлөмж	1				1	-	-
Нийт дүн	2	245.3	1	245.3	1		75,0

Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1.Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн нийт 1,229.0 мянган төгрөгийн алдаа, зөрчлийн илэрч 3 зөвлөмж өглөө.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс бараа материалын 324.8 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас санхүүжүүлсэн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2 дахь “Төсвийн иж бүрэн, **үнэн зөв** байдлыг хангасан байх” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул зардлыг бодит тооцоо судалгаан дээр үндэслэж, үнэн зөв төлөвлөж, хэрэгжүүлэх.

2. Төлбөрийн баримттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Тайлант онд 278.1 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

3. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Цалин хөлснөөс суутгасан татварын дүнг татварын тайлангийн дүнгээс 245.3 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан дахь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн дүнгээс 380.8 мянган төгрөгөөр тус тус дутуу илэрхийлсэн байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2. “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, ...бүртгэж, тайлагнах” гэж заасныг зөрчиж байгаа тул санхүүгийн тайланг журам, зааврын дагуу үнэн зөв тайлагнаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/ Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сант сумын 1 дүгээр цэцэрлэг	3	2,229.0			-	-			3	1,229.0

4